



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/43

Амардалай

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, “ж”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой Комиссын 2020 оны 13 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой Комиссын 09 дүгээр хуралдааны шийдвэр, аймгийн Засаг даргын 2020 оны А/85 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацааг сунгасантай холбогдуулан соёл урлаг, спорт болон олон нийтийг хамарсан бүх төрлийн үйл ажиллагааг 2020 оны 04 дүгээр сарын 30 ныг өдрийг дуустал хориглосугай.

Хоёр: Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй газруудын зөвхөн архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хуваарийг 2020 оны 03-р сарын 30 ны өдрөөс 04-р сарын 30 ны өдрийг дуустал 09.00-15.00 цаг хүртэл байхаар мөрдүүлсүгэй.

Гурав: Захирамжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч /З.Наранмандах/, Хэсгийн төлөөлөгч /Л.Отгонбаатар/, хэсгийн цагдаа Б.Насанжаргал/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ЦОЛМОНБААТАР